



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/16-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Цагааннуур сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.4.2 Авлага	11
3.4.3 Бараа материал.....	12
3.4.4 Үндсэн хөрөнгө	12
3.4.5 Өр төлбөр.....	13
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.4.6 Зардлын данс	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6.1 Завсрын аудитын талаар.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.БАЯНБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.25 № 076-2023/16-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цагааннуур сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтээс татварын ба татварын бус орлогын бүрдүүлэлт 112.8 хувиар биелсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 79.6 хувьтай тайлагнагдсан нь ОНХС-ийн эх үүсвэрээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 33.4 хувь нь хэрэгжээгүй, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийг олгоогүй зэргээс голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Цагааннуур сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 41.5 хувь буюу 573,891.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 360,851.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 44,858.0 мянган төгрөг, нормативт

018020339
3

зардалд 559.8 мянган төгрөг, тавилга эд хогшил, урсгал засварын зардалд 61,864.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55,228.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгд 21,554.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 656,495.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	990,275.9	851,336.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	445,143.4	636,085.2
33	АВЛАГА	269,445.9	144,438.6
35	БАРАА МАТЕРИАЛ	275,686.6	70,812.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,382,114.2	8,577,167.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,382,114.2	8,577,167.9
39200	Биет хөрөнгө	13,262,233.1	8,500,414.9
39300	Биет бус хөрөнгө	119,881.1	76,753.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,372,390.0	9,428,504.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	101,558.9	68,701.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	101,558.9	68,701.4
41300	Өглөг	101,558.9	68,701.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,270,831.2	9,359,802.8
51	Засгийн газрын хувь оролцоо	14,270,831.2	9,359,802.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,076,822.9	1,588,489.6
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,076,822.9	1,588,489.6
51200	Хуримтлагдсан үр дүн	8,458,990.3	7,052,785.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,735,018.0	718,527.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,372,390.0	9,428,504.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,789,503.4	3,189,163.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	367,718.8	1,029,273.3
110	Орлогын албан татвар	131,995.8	409,280.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	131,995.8	409,280.1
113	Хөрөнгийн албан татвар	78,091.2	217,810.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	157,631.8	402,182.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,670,009.2	859,473.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,670,009.2	859,473.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,751,775.3	1,300,416.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,082,334.9	1,867,873.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,082,334.9	1,867,873.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,010,718.7	1,800,678.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,447,153.9	515,909.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	320,727.0	64,463.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,364.4	360,851.7
2104	Хангамж, бараа материалын зардал	133,454.6	51,441.4
2105	Нормативт зардал	261,692.2	559.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,562.1	167,599.8
2107	Томилолт, зочны зардал	5,273.4	14,036.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,555.5	27,373.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	526,935.6	598,443.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,071,616.2	67,194.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,707,168.5	1,321,290.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	103,223.5	6,270,337.7

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,603,945.0	-4,949,047.5
----	---	-------------	--------------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,659,541.6	0.0	12,659,541.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,410.0	0.0	3,410.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,662,951.6	0.0	12,662,951.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-259.5	0.0	-259.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,194.0	0.0	4,194.0
9	Тайлант үеийн үр дүн	1,603,945.0	0.0	1,603,945.0
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,270,831.2	0.0	14,270,831.2
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,270,831.2	0.0	14,270,831.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,652.8	0.0	-7,652.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,263,178.4	0.0	14,263,178.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,672.0	0.0	45,672.0
19	Тайлант үеийн үр дүн	-4,949,047.5	0.0	-4,949,047.5
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,359,802.8	0.0	9,359,802.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,159,836.8	2,450,091.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	367,718.8	1,029,273.3
110	Орлогын албан татвар	131,995.8	409,280.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	131,995.8	409,280.1
113	Хөрөнгийн албан татвар	78,091.2	217,810.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	157,631.8	402,182.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,058.9	263,583.6
1181	Газрын төлбөр	24,574.0	49,273.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	124,999.0	89,325.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,340.1	123,072.0
120	Нийтлэг татварын бус орлого	116,340.1	123,072.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,675,777.9	1,297,746.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,602,363.2	1,216,293.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,602,363.2	1,216,293.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,530,994.4	1,191,576.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,447,630.5	514,716.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	320,250.3	63,668.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,364.4	360,851.7
2104	Хангамж, бараа материалын зардал	87,229.8	50,416.0
2105	Нормативт зардал	259,960.3	559.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,750.1	66,715.1
2107	Томилолт, зочны зардал	5,273.4	14,036.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,603.5	23,775.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,932.1	96,837.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,071,368.7	24,717.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	557,473.6	1,233,797.8

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	181,250.4	1,042,856.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,250.4	1,042,856.0
2200	Дотоод эх үүсвэрээр	181,250.4	1,042,856.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-181,250.4	-1,042,856.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-46,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	46,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	330,223.2	190,941.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114,920.1	445,143.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	445,143.4	636,085.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,269,420.4	1,806,413.4	-463,007.0	79.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,759.3	1,149,917.8	-54,841.5	95.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,183,160.5	1,128,363.0	-54,797.5	95.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531,320.3	510,433.3	-20,887.0	96.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,308.5	63,458.5	-3,850.0	94.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	372,367.4	360,851.7	-11,515.7	96.9
2104	Хангамж, бараа материалын зардал	45,957.1	44,858.0	-1,099.1	97.6
2105	Нормативт зардал	1,199.2	559.8	-639.4	46.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,787.7	61,864.9	-1,922.8	97.0
2107	Томилолт, зочны зардал	11,585.5	10,518.8	-1,066.7	90.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,789.1	20,590.0	-2,199.1	90.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,845.7	55,228.0	-11,617.7	82.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,598.8	21,554.8	-44.0	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,598.8	21,554.8	-44.0	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	953,473.0	656,495.6	-296,977.4	68.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	111,188.1	0.0	-111,188.1	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,269,420.4	1,865,361.8	-404,058.6	82.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,959,576.8	1,775,603.9	-183,972.9	90.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	309,843.6	89,757.9	-220,085.7	29.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	130,453.8	130,453.8	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	189,398.0	189,398.0	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	148.0	166.0	18.0	112.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4.0	4.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	72.0	81.0	9.0	112.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	72.0	81.0	9.0	112.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	495,213.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,685.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,045.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,283.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209.90
2104	Хангамж, бараа материалын зардал	5,557.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,650.00
2107	Томилолт, зочны зардал	3,517.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,532.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,294.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,639.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,158.30
3133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,481.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	325,528.80
2200	Дотоод эх үүсвэрээс	325,528.80
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	495,213.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	495,213.90
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагааннуур сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын Засаг даргыг үйл ажиллагаагаа явуулахад нь мэргэшлийн зөвлөгөө мэдээллээр хангах, зөвлөн туслах, төрийн үйлчилгээний тасралтгүй хэвийн жигд үйлчилгээг хангаж иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчилж ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны ИТХ-ын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;
- Татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт,

хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ. Тайлант онд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цагааннуур сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,937,384.0 мянган төгрөгөөр буюу 34.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	445,143.4	636,085.2	190,941.8
Авлага	269,445.9	144,438.6	-125,007.3
Бараа материал	275,686.6	70,812.5	-204,874.1
Үндсэн хөрөнгө	13,382,114.1	8,577,167.9	-4,804,946.2
Нийт хөрөнгө	14,372,390.0	9,428,504.2	-4,943,885.8
Өр төлбөр	101,558.8	68,701.4	-32,857.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,270,831.2	9,359,802.8	-4,911,028.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,372,390.0	9,428,504.2	-4,943,885.8

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 636,085.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 190,941.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	445,143.4	636,085.2	190,941.8
Төгрөг	445,143.4	636,085.2	190,941.8
Төрийн сангийн харилцах	445,143.4	636,085.2	190,941.8
Дүн	445,143.4	636,085.2	190,941.8

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 446,687.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 91,327.2 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 98,070.8 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 144,438.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 125,007.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	3,461.3	0.0	-3,461.3
Татаас, санхүүжилтийн авлага	77,403.7	0.0	-77,403.7
Зээлийн хүүгийн авлага	8,402.7	2,680.4	-5,722.3
Байгууллагаас авах авлага	1,498.3	57.3	-1,441.0
Хувь хүмүүсээс авах авлага	178,679.9	141,700.9	-36,979.0
Дүн	269,445.9	144,438.6	-125,007.3

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 44,066.7 мянган төгрөгийн хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлага байна.

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 99.9 хувь буюу 144,381.3 мянган төгрөгийг хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна.

Насжилт өндөртэй буюу 2011-2018 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн 57,909.1 мянган төгрөгийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 70,812.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 204,874.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	18,504.8	570.0	-17,934.8
Тусгай зориулалттай материал	3,023.5	570.0	-2,453.5
Эм боох материал	15,481.3	0.0	-15,481.3
Хангамжийн материал	257,181.8	70,242.5	-186,939.3
Бичиг хэргийн материал	109.5	0.0	-109.5
Аж ахуйн материал	240,293.6	70,027.1	-170,266.5
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	3,167.9	0.0	-3,167.9
Бусад хангамжийн материал	13,610.8	215.4	-13,395.4
Мал амьтад	0.0	0.0	0.0
Дүн	275,686.6	70,812.5	-204,874.1

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 204,874.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 983,831.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 27,363.8 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан болон 490,310.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 476,168.4 мянган төгрөгийг шилжүүлж, бүтцийн өөрчлөлтөөр сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд нь улсын төсөвт байгууллага болсноор хаалтын тайлан гаргаж, тухайн байгууллагуудын 248,564.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, 1,025.5 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийт 37,607.0 мянган төгрөгийн /ЗДТГ нь 28,557.0 мянган төгрөг, Ойн анги 9,050.0 мянган төгрөг/ бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл /анхны өртгөөр/ 10,708,639.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,988,100.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	15,575,871.0	10,631,886.7	-4,943,984.3
Барилга, байгууламж, орон сууц	11,394,966.9	6,955,570.7	-4,439,396.2
Авто-тээврийн хэрэгсэл	258,375.8	238,753.3	-19,622.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	801,902.9	422,582.9	-379,320.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	419,851.5	80,597.2	-339,254.3

Дуусаагүй барилга байгууламж	85,805.6	63,072.8	-22,732.8
Номын фонд	72,167.4	0.0	-72,167.4
Бусад үндсэн хөрөнгө	2,542,800.9	2,871,309.8	328,508.9
Биет бус хөрөнгө	120,869.0	76,753.0	-44,116.0
Программ хангамж	1,290.0	0.0	-1,290.0
Бусад биет бус хөрөнгө	119,579.0	76,753.0	-42,826.0
Дүн	15,696,740.0	10,708,639.7	-4,988,100.3

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 4,988,100.3 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 82,781.7 мянган төгрөгийн хөрөнгө /6,320.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 53,484.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 17,479.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 5,497.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө/ худалдан авсан,
- Үнэ төлбөргүйгээр 5,357.6 мянган төгрөгийн хөрөнгө /Сумын иргэнээс ИТХ-д 2,500.0 мянган төгрөгийн мотоцикл, ХАА газраас ЗДТГ-т 2,857.6 мянган төгрөгийн хүлэмж/ үнэ төлбөхгүй хүлээн авсан,
- ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 457,911.3 мянган төгрөгийн хөрөнгө /Ойн анги нь сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 11,333.0 мянган төгрөгийн мод үржлийн газрын хашаа, байшин, ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 35,848.3 мянган төгрөгийн “Сити нойл” нийтийн бие засах газар, 96,604.2 мянган төгрөгийн хатуу хучилттай замын үргэлжлэл, 74,044.9 мянган төгрөгийн ногоон байгууламжийн тохижилт, 27,543.6 мянган төгрөгийн гудамж талбайн камержуулалт, 48,200.0 мянган төгрөгийн бохирын машин, 164,343.3 мянган төгрөгийн хогийн цэгийн хашаажуулалт, камержуулалт/ орлогод авсан,
- 334,136.3 мянган төгрөгийн бусад хөрөнгө /Спорт цогцолбор нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 283,715.5 мянган төгрөгийн урсгал засварыг капиталжуулсан, Ойн анги нь БОАЖГ-аас 45,672.0 мянган төгрөгийн мод үржүүлгийн хашаа байшингийн газар, 4,748.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж/ орлогод авсан,
- Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд нь улсын төсөвт байгууллага болсноор хаалтын тайлан гаргаж, тухайн байгууллагуудын 5,809,663.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж хасагдсанаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

- ЗДТГ-ийн 2018-2022 онуудад орлого авсан 3 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 3,159.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 101,558.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 68,701.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 32,857.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	1,988.2	1,988.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	43,935.2	24,533.7	-19,401.5
Байгууллагад төлөх өглөг	57,623.6	42,179.5	-15,444.1
Дүн	101,558.8	68,701.4	-32,857.4

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст өр төлбөр данс үлдэгдэл нь 32,857.4 мянган төгрөгөөр буурсан нь ЭМТ нь ковид -19 цар тахалтай холбоотой эм, эмнэгийн хэрэгслийн 74,556.5 мянган төгрөгийн өглөг буурч, ЭМЯ-нд шилжсэнээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс Орхон бүсийн Ойн анги нь 1,988.2 мянган төгрөгийн НДШ, ХАОАТ-ын өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,359,802.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,911,028.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,076,822.9	1,588,489.6	-1,488,333.3
Хуримтлагдсан үр дүн	8,458,990.3	7,052,785.5	-1,406,204.8
Өмнөх үеийн үр дүн	6,855,045.3	12,001,833.0	5,146,787.7
Тайлант үеийн үр дүн	1,603,945.0	-4,949,047.5	-6,552,992.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,735,018.0	718,527.7	-2,016,490.3
Дүн	14,270,831.2	9,359,802.8	-4,911,028.4

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 4,911,028.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 6,552,992.5 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

3.4.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **1,752.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1.5 сарын үндсэн цалинг урамшуулал олгох шийдвэрийг үндэслэн сумын төрийн сангийн мэргэжилтэн Ц.Батдэлгэрт 475.8 мянган төгрөг, нягтлан бодогч

Д.Энхжаргалд 381.2 мянган төгрөг зэрэг нийт 857.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон,

- Ойн анги нь дарга Н.Амаржаргалын хувийн дансаар дамжуулан 895.5 мянган төгрөгийн материал худалдан авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Цагааннуур сумын ИТХ-ын 2021 оны “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 61 дүгээр тогтоолоор 932,511.2 мянган төгрөгийн татварын орлого, 21,500.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,075,994.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 12.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

<i>/мянган төгрөг/</i>				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	932,511.20	1,029,273.29	96,762.09	110.4
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	305,000.0	310,832.1	5,832.1	101.9
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	19,700.0	53,366.4	33,666.4	270.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	44,500.0	38,423.2	(6,076.8)	86.3
Хөрөнгийн орлого	44,100.0	39,691.6	(4,408.4)	90.0
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	10,100.0	5,390.0	(4,710.0)	53.4
Бууны албан татвар	1,500.0	1,952.0	452.0	130.1
Малд ногдуулах албан татвар	355,041.2	177,435.5	(177,605.8)	
Улсын тэмдэгтийн хураамж	3,700.0	3,183.6	(516.4)	86.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,125.0	257,628.0	255,503.0	12,123.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	2,772.0	(3,228.0)	46.2
Газрын төлбөр	68,384.4	48,115.9	(20,268.5)	70.4
Газрын дуудлага худалдаа	15,000.0	1,157.6	(13,842.4)	7.7
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	57,062.6	88,039.4	30,976.8	154.3
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	208.0	346.0	138.0	166.3
Байгалийн ургамал ашигласны төлбөр	90.0	940.0	850.0	1,044.4
Татварын бус орлого	21,500.0	46,721.3	25,221.3	217.3
Хүү, торгуулийн орлого	20,000.0	45,317.3	25,317.3	226.6
Бусад орлого	1,500.0	1,404.0	(96.0)	93.6

Нийт дүн	954,011.2	1,075,994.6	121,983.4	112.8
-----------------	------------------	--------------------	------------------	--------------

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 5,832.1 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын орлого 33,666.4 мянган төгрөг, бууны албан татвар 452.0 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 255,503.0 мянган төгрөг, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 30,976.8 мянган төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлого 138.0 мянган төгрөг, байгалийн ургамал ашигласны төлбөр 850.0 мянган төгрөгөөр тус тус давсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 6,076.8 мянган төгрөг, хөрөнгийн орлого 4,408.4 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 4,710.0 мянган төгрөг, малд ногдуулах албан татварын орлого 177,605.8 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 516.4 мянган төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 3,228.0 мянган төгрөг, газрын төлбөр 20,268.5 мянган төгрөг, газрын дуудлага худалдаа 13,842.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ХХОАТ-ын орлого 33,666.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь улаан буудай болон ноосны урамшууллаас суутгасан орлого төвлөрснөөс шалтгаалсан,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 255,503.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь Шаамар сумаас Түшиг сум хүртэлх хатуу хучилттай зам тавьж байгаатай холбоотой карьер ашигласны төлбөр төвлөрснөөс шалтгаалсан,
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 30,976.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь сумын бүс нутагт мод бэлтгэл өссөнөөс шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 6,076.8 мянган төгрөгөөр тасарсан нь татвар төлөх нэхэмжлэл дутуу үүссэнээс шалтгаалсан,
- Малд ногдуулах албан татварын орлого 177,605.8 мянган төгрөгөөр тасарсан нь татварын хувь хэмжээ өндөр гэсэн шалтгаанаар зарим малчид татвар төлөхгүй байгаагаас шалтгаалсан,
- Газрын төлбөрийн орлого 20,268.5 мянган төгрөгөөр тасарсан нь татвар төлөх нэхэмжлэл дутуу үүссэнээс шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдааны орлого 13,842.4 мянган төгрөгөөр тасарсан нь зохион байгуулахаар төлөвлөсөн дуудлага худалдаа бүрэн зохион байгуулагдаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 974,848.7 мянган

төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 99,967.0 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 16,125.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг 1,090,940.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 41 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 969,011.2 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 561,680.6 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 42,129.2 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 371,234.5 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 380,276.3 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 57,438.1 мянган төгрөг зэрэг нийт **2,381,769.9** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 61 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг бууруулж 2,269,420.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Малд ногдуулах албан татварын орлогыг 25,000.0 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнг 33,033.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 130,382.5 мянган төгрөгөөр, цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 40,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,
- ИТХ-ын урсгал зардлыг 8,299.9 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын урсгал зардлыг 49,012.1 мянган төгрөгөөр, ойн ангийн тогтмол зардлыг 2,300.0 мянган төгрөгөөр, соёлын төвийн тогтмол зардлыг 18,456.3 мянган төгрөгөөр, ОНХС-г 25,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ЕБС, цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлуудыг 172,838.8 мянган төгрөгөөр, ОНХО-ын зардлыг 42,579.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 431,298.1 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 371,234.5 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 413,309.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 57,438.1 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 954,011.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 42,129.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,269,420.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 431,298.1 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 371,234.5 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 1,075,994.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 47,056.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **1,925,583.7** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,806,413.4** мянган төгрөг буюу **79.6** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 20,887.0 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 11,515.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,617.7 мянган төгрөгөөр эргэж төлөгдөх

зээлийн зардал 111,188.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 20 төсөл, арга хэмжээнд 881,052.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 677,490.0 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 91,327.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь зураг төсөв хийлгээгүй 3 төсөл, арга, малын тоо толгойн албан татварын орлогоор хийх 1 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжээгүй нь уг орлого тасарснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 9,588.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 406,021.8 мянган төгрөг /ОНХО, ОНХС-аас эрх шилсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 378,964.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын санхүүжилт 4,692.8 мянган төгрөг, нийтийн биеийн тамирын арга хэмжээний 800.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хамтарсан багийн санхүүжилт 1,564.9 мянган төгрөг, БОАЖГ-аас дэмжлэг үзүүлэх ажлын санхүүжилт 20,000.0 мянган төгрөг/, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 79,603.5 мянган төгрөг зэрэг нийт 495,213.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 169,685.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 325,528.8 мянган төгрөг зэрэг нийт 495,213.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур сумын ТТЗ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Байгууллагын мөнгөн кассын гүйлгээг журмын дагуу хийх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 46 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4,157,808.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **41,578.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг болсон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,818,889.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **27,283.3** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Цагааннуур сумын ТТЗ нь батлагдсан төсвийг 20.4 хувиар хэмнэсэн болон бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашиглаж, бичиг хэргийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчсөн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Монголын нутгийн удирдлагын холбооноос Улаанбаатар хотод зохион байгуулсан “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн албаны ёс зүй” сэдэвт сургалтад ЗДТГ-ын албан хаагчид хамрагдаж, албан томилолтын зардалд 1,830.4 мянган төгрөг, сургалтын төлбөрт 500.0 мянган төгрөг зэрэг нийт 2,330.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-дахь ” Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	150	5	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	151		
3	Засаг даргын Тамгын газар	151	148	3	
4	Орхон бүсийн ойн анги	151	151		
	Нийт дүн	608	600	8	

Эх сурвалж: old.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 608 мэдээллээс 600 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 60,846.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,380.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 59,465.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,380.2	1	1,380.2	100.0
Зөвлөмж	5	59,465.9	4	43,369.8	80.0
Нийт дүн	6	60,846.1	5	44,750.0	83.3

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан зөрчил дараах шийдлүүдийг хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4.7.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалт, ОНХ-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудит болон бусад аудитиудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4.7.2 Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 144,381.3 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 2011-2018 онд олгосон 8 иргэний 57,909.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай юм.

4.7.3 Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Т.Отгонсүрэнд сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн гэж **5,340.1** мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгох Засаг даргын 2022 оны Б/22 дугаар захирамжийн хууль, эрх зүйн актыг буруу сонгож хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.3 дугаар зүйлийг бус Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн

дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно” гэсэн заалтыг үндэслэсэн байна. Цаашид захирамжийн хууль, эрх зүйн үндэслэлийг зөв сонгож хэрэглэх нь зүйтэй юм.

4.7.4 Аймгийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр Санхүүгийн албаны дарга Х.Дашцэрмаагийн үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэрийг үндэслэн 1,386.7 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.”

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **3,159.1** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг залруулагдаагүй алдаагаар бүртгэж, зөвлөмж өгөв. Үүнд:

- ЗДТГ-ын 2018-2022 онуудад орлого авсан 3 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 3,159.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.6 “бүх зардал”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.35 дахь “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: 2023 оны 2-р улиралд багтаан үндсэн хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцох.

Аудитаар нийт **27,178.1** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 26,282.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 895.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүрүүлсэн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийт **21,107.0** мянган төгрөгийн /ЗДТГ нь 12,057.0 мянган төгрөг, Ойн анги 9,050.0 мянган төгрөг/ бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй буюу зөрчлийг давтан гаргасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “ ... Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1.2 Сумын ЗДТГ-ын даргын 2022 оны Б/21 дүгээр тушаалаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэр гаргаж, төрийн сангийн мэргэжилтэн Ц.Батдэлгэрт 475.8 мянган төгрөг, нягтлан бодогч Д.Энхжаргалд 381.2 мянган төгрөг зэрэг нийт **857.0** мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын ажлын мөнгөн урамшууллыг давхардуулан олгохгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.1.3 Монголын нутгийн удирдлагын холбооноос Улаанбаатар хотод зохион байгуулсан “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн албаны ёс зүй” сэдэвт сургалтад ЗДТГ-ын албан хаагчдыг хамруулж, албан томилолтын зардалд 1,830.4 мянган төгрөг, сургалтын төлбөрт 500.0 мянган төгрөг зэрэг нийт **2,330.4** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.1.4 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс Орхон бүсийн Ойн анги нь **1,988.2** мянган төгрөгийн НДШ, ХАОАТ-ын өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өглөг үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1. Мөнгөн кассын ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Ойн анги нь дарга Н.Амаржаргалын хувийн дансаар дамжуулан **895.5** мянган төгрөгийн материал худалдан авсан нь Сангийн сайдын 2012 оны 276 дүгээр тушаалаар баталсан “*Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам*”-ын 3.2 дахь “*Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын мөнгөн кассын гүйлгээг журмын дагуу хийх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	3,159.1	1	3,159.1					1	3,159.1	1	3,159.1
Дүн	1	3,159.1	1	3,159.1					1	3,159.1	1	3,159.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗДТГ	4	15,244.4			3	15,244.4							
Ойн анги	3	11,933.7			2	11,038.2	1	895.5					
Дүн	7	27,178.1			5	26,282.6	1	895.5					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								